



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 0/417

Есөнбулаг

Гэрээ шууд байгуулж, гүйцэтгүүлэх эрх
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэх тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн орон сууц, албан байгууллагын гадна фасадны өнгө сэргээх ажлын байршил, төсөвт өртөгийг хавсралтаар баталж, шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т шилжүүлсүгэй.

2.Хавсралтад дурдсан төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 20... оны ... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
САНХҮҮЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Багцын дугаар	Барилгын нэр	Төсөвт өртөг (төгрөг)
Багц 1	1-р байр	6,170,184
	2-р байр	6,170,184
	Дүн	12,340,368
Багц 2	8 дугаар байр	5,166,016
	9 дүгээр байр	5,166,016
	13 дугаар байр	6,273,020
	Дүн	16,605,052
Багц 3	22 дугаар байр	15,788,412
	21 дүгээр байр	11,735,448
	Дүн	27,523,860
Багц 4	24 дүгээр байр аюулгүй тойрог	3,197,002
	23 дугаар байр Урчуудын байр	4,072,119
	Дүн	7,269,121